

ОХУ-ЫН ЗҮҮН АЗИЙН БОДЛОГО: ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ

К.Дэмбэрэл*

1. Зүүн Азид нөлөөгөө өргөжүүлэх бодит үндэслэл

Европ руу хандсан нэг талт бодлого, үйл ажиллагаа нь ОХУ-ыг ганц зах зээлээс хэт хараат байдалд оруулж, тэрээр “эрсдэлтэй” алхам гэдгийг санхүүгийн хямралын үеэр мэдрүүлсэн. ОХУ-ын хувьд эдийн засаг, соёлын хувьд Европоос хамааралтай байдал нь хэдийгээр олон зууны үүдэлтэй ч дэлхийн хэмжээнд санхүү, эдийн засгийн шинэ “хуваарилалт” бий болж буйг ашиглан тэр урсгалд орохын зайлшгүйг цаг үе нь шаардаж байна. Тухайлбал, сүүлийн 10 жилд Азийн зөвхөн 11 улстай хийж буй худалдаа нь Оросын гадаад худалдааны 13,4 хувьд хүрсэн. Дараагийн 10-15 жилд энэ үзүүлэлт 20 хувь хүрэх боломжтой хэмээн зарим судлаачид¹ үзэж байгаа бол зарим нь бүр эрчим хүчний эх сурвалжийг тогтвортой нийлүүлэх болсноор 33-35 хувьд хүрэх боломжтойг тэмдэглэж байна. Өөрөөр хэлбэл, Оросын гадаад худалдааны нийт эргэлтийн 30 гаруй хувь нь Зүүн Азид ноогдоно гэсэн үг.

Зүүн Азид эдийн засгийн хамтын ажиллагааг өргжүүлэх бодит үндэслэлийн тухайд гэвэл: **Нэгд**, 2010 оны байдлаар Хятадын ДНБ -9,8 трлн ам доллар, Японых 4,2 трлн ам доллар, Өмнөд Солонгосынх 1,4 трлн ам доллар буюу зөвхөн эдгээр улсуудын нийлбэр 15,4 трлн ам доллар буюу Европын Холбоотой /15,2 трлн ам.доллар/ тэнцүү болж АНУ-аас /14,8 трлн ам доллар/ давж² гарлаа. Энэ нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн 3 том төвийн нэг нь Зүүн Ази болсны илэрхийлэл. **Хоёрт**, ОХУ-ын Алс Дорнодын бүс нутаг нь Япон, Хятад, Солонгостой шууд холбогдож байгаа төдийгүй хамтын ажиллагааг өргөжүүлэх дэд бүтцийн болон бусад бааз суурьтай. **Гуравт**, ОХУ-ын гадаад худалдааны нийт эргэлт 2010 оны байдлаар 625,4 тэрбум ам.доллар байж, 49 хувь нь ЕХ-нд, 59,3 тэрбумын бараа эргэлт Хятадад, 23,1 тэрбумын бараа эргэлт Японд, 17,7 тэрбумын бараа эргэлт Өмнөд Солонгост ногдож³ байгаа ба энэхүү эдийн засгийн томоохон төвд ОХУ-ын гадаад худалдааны нийт эргэлтийн даруй 16 хувь ногдож байна.. Оросын гадаад худалдааны онцлог бол нийт экспортын 70,8 хувийг эрчим хүчний эх сурвалж эзэлж байгаа явдал.

Европ, Азийг дамнасан өргөн уудам газар нутгаа “капиталжуулах” гэсэн оросын судлаачдын санаанд, ашигт малтмал, дамжих тээвэр, олзворлолтоос гадна түүнийг өөр олон зорилгоор ашиглах нь чухал гэж үзсэн. Тухайлбал, хүнс, ХАА-н чиглэлээр ашиглах, хүнс экспортлох, Лондон-Шанхай гэсэн тээврийн коридор бий болгох, “транссиб”-ээс гадна, хойд далайн тээвэр ч яригдаж байгаа. Гэтэл Төв Азид торгоны замыг сэргээх талаар идэвхитэй яриаг Хятадын талаас

* К.Дэмбэрэл - ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

явуулж байгаа нь Оросыг тойрох гэсэн хятадын бодлого учраас Оросыг дайрсан тээврийн коридорт нэлээн саад бий болно.

Хятад, Японы зүгээс Зүүн Азид тогтворгүй байдлын үндсэн шалтгаан нь ЗХУ байсан ба түүний задрал бүс нутагт улс төрийн тогтвортой, аюулгүй байдлыг бий болголоо хэмээн үздэг. Гэхдээ аюулгүй байдлын хүчин зүйл ч “хүйтэн дайны” дараа ч Азид ач холбогдол нь хэвээр байгаа. Азийн улс орнууд тусгаар байдлаа чухалчлахдаа харилцаа хамтын ажиллагаа нь энэхүү тусгаар байдлыг эвдэхгүй байхад л гол анхаарал чиглэгдэх ёстойг эрхэмлэж байна. Эдгээр нь ОХУ-ыг “Азийн интеграцчлалд үр ашигтай оролцох бааз суурийг бий болгож байна”.⁴

ОХУ-ын хувьд Зүүн Азид нөлөө бүхий тоглогч байхаа больсон өнөөгийн нөхцөлд АНУ, Японы зүгээс энэ бүс нутагт Оросод худалдаа-эдийн засгийн салбарт “буулт” хийгээд байх шаардлагагүй байгаа. Бүс нутгийн зарим улсуудтай явуулж буй цэрэг, батлан хамгаалах чиглэлийн хамтын ажиллагаанд нь дээрхи улсуудын зүгээс зохих хэмжээнд шахалт үзүүлэх тал ч бий хэмээн оросууд бичиж байна. ОХУ-ын зүгээс бүс нутгийн аюулгүй байдлын салбарт явуулж буй “идэвхигүй”, “өнөө, маргаашийн” шинжтэй бодлого нь АНУ, Япон, Хятадын хувьд таатай зүйл. Гэхдээ энэ байдал нэг их удаан үргэлжлэхгүй гэдгийг ч бүгд ойлгож байгаа. ОХУ нь Зүүн Азид АНУ-ын давамгайлсан байдлыг ч таашаахгүй. Тийм байр суурийг БНХАУ ч баримталсаар буй. Зүүн Азид Япон, Өмнөд Солонгост түшиглэсэн АНУ-ын байр суурь нэмэгдсэн бөгөөд тэдний зорилго бол Хятад, ОХУ-ын цэргийн хүчийг нэмэгдүүлэхийг аль болох хориход чиглэгдэж байгаа. Зүүн Азид ОХУ-ын байр суурийг нэмэгдүүлэхийн эсрэг үйлдэл голлон АНУ-аас гарч байгаа гэсэн оросын судлаачдын “хардлага” ч бий. АНУ, ОХУ-ын байр суурийн зөрөө нэмэгдээд ирэхээр сонирхлын зөрчилтэй улсуудын хүрээ тэлээд асуудал ч эргэж таарна. Хятадын зарим судлаачид ойрын ирээдүйд тойруу замаар ч болов “АНУ, ОХУ хоёрын сонирхол Ойрхи Дорнод, Зүүн Европт мөргөлдөж таарна” хэмээн үзэж /Гао Хэн-БНХАУ-ын НШУА-ийн дэлхийн улс төр, эдийн засгийн хүрээлэн/ байгаа.

Зүүн Азид худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжихийн хэрээр түүний аюулгүй байдал, улс төрийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн цэрэг, батлан хамгаалахын хүч чадлыг нэмэгдүүлэхийг шаардана. Орос, хятадын стратегийн холбоо нь Зүүн Азид АНУ-ын хэт илүү байдлыг хязгаарлаж бүс нутгийн олон асуудлыг шийдэх боломжтой гэсэн зарим судлаачдын дүгнэлт бий. Гэхдээ Орос ч, Хятад ч аль алин АНУ-тай сөргөлдөх бодит сонирхол байхгүй байгаа. Алсдаа БНХАУ-ын хувьд АНУ нь стратегийн өрсөлдөгч тул Орос нь хятадтай стратегийн түншлэлийн шугамаар л байр сууриа бэхжүүлж чадна. АНУ-Японы аюулгүй байдлын гэрээний хэмжээний утга агуулга бүхий гэрээг Орос-Хятадын хооронд

байгуулж чадваас Зүүн Азид Япон-Америкийн давамгайллыг устгаж, өөрсдийн санаа бодлоо бүс нутгийн бусад улсуудад тулгах боломж нээгдэнэ.

2. Зүүн Азид явуулах ОХУ-ын улс төр, эдийн засгийн бодлого, стратеги

Зүүн Ази нь бүс нутгийн хэмжээнд аюулгүй байдал, хамтын ажиллагааны өөрийн механизмыг бий болгохоор ажиллаж байгаа. Урьд нь оршиж ирсэн механизм нь тодорхой хэмжээнд бүс нутгийн бус тэнд давамгайллагч хүчний сонирхлыг хамгаалж ирсэн тал бий. ОХУ-ын хувьд энэ бүрэлдэн бий болох механизмыг дэмжин тэнд зохих байр суурьтай оролцох нь зүйтэй⁵ юм.

Орос, Хятадын худалдаа нь түүхий эд дээр /нефть, хий, мод/ тулгуурласан бүтцээс мөлдөө ангижрахгүй. Гэхдээ үүнд бас санаа зовохгүй байгаа, учир нь энэ байдалд харьцангуй эвлэрсэн шинжтэй байгаа. Харин худалдааны балансад хятадын экспорт давамгайлсан нь оросуудыг түгшээж байна. Хоёр орны худалдааны зөрүү нь 2010 оны байдаар 20.0 орчим тэрбум ам.долларт хүрсэн. Бүр тодруулбал, машин, тоног төхөөрөмжийн хятадын экспорт нэмэгдэж байгаад л оросууд “дурамжхан” байна. Оросуудын машин, тоног төхөөрөмжийн хятад руу чиглэсэн экспорт жил бүр 2%-иар хорогдсоор⁶ байгаа.

Оросуудын хувьд Хятадаар дамжуулан Зүүн Азид гарах вариантыг нэлээн дургүй авч үзэж байгаа бол хятадууд чухам л өөрсдөөрөө дамжуулж гаргах сонирхол их байгаа.

Эрчим хүчний эх сурвалжийг Хятадад хүргэх “богино чиглэл”, эсвэл далайд гаргаад олон улсад хүргэх гэсэн 2 гарц яригдаж байгаа ба эхнийх нь Хятадын санхүүжилтээр тул нэлээн “тулгагдсан” шинжтэй байгаа.

Зүүн Азид гарахдаа бүс нутгийн нөлөө бүхий улсуудтай дангаар гарч харьцах аль эсвэл бүс нутгийн бүтцээр /АСЕАН, АТЭС, бусад/ дамжуулан гарах гэсэн 2 вариант байгаа. ЗХУ-ын нөлөөнд зохих хэмжээнд байсан Вьетнам, Лаос, Индонез, Кампучи, Хойд Солонгос, Энэтхэг зэрэг улсуудтай хоёр талын харилцааг сайжруулах бодлого явуулах боллоо.

АНУ, Хятадын сөргөлдөөний үед ОХУ-ын үүрэг ямар байх, тэндээс олж болох ашиг юу байх талаар одоо стратегиа боловсруулах талаар судлаачид бичиж байна. Энэ сөргөлдөөний үед Хятад Номхон далайгаар хаагдах боломжтой тул хуурай газраар хиллэдэг ОХУ-аас түүхий эдээ хангах нэн ялангуяа Зүүн хойд хилээр шууд харьцааг түлхүү хийгдэх боломжтой. Хятадын хувьд баруун хойд хилээр асуудал ихтэй байгаа. ОХУ дахь хятадын лобби, евро-атлантын лобби 2 ширүүн тэмцэлд орох нь гарцаагүй. Тиймээс АНУ нь ОХУ-ыг Хятадын түүхий эдийн бааз байх нөхцлийг одооноос хаах бодлого явуулах магадлалтай.

Зүүн Азид явуулах улс төрийн шинэ бодлогоо томъёолохдоо эдийн засгийн сонирхлоо түлхүү тавих болсноор бодлогын хэрэгжилт

удааширалттай байгаа. Энэ бодлого хэрэгжснээр эдийн засгийг бодитоор урагшуулна хэмээн улс төрчдийн болон судлаачдын хүрээнд үзэж байгаа. Бүс нутагт чиглэсэн бизнесийн “давшилт” хэрэгтэй байна хэмээн ч үзэж байгаа. Зүүн Азид эрчим хүчний эх сурвалж нийлүүлэгчдийн бүтэц ч өөрчлөгдөж байна. Оросын хувьд эрчим хүчний эх сурвалжийг БНХАУ, цаашлаад Зүүн Азийн зах зээлд гаргах төслүүд сонирхолтой байгаа.

Зүүн Азид ОХУ-ын идэвхитэй үйл ажиллагаа, хамтын ажиллагааг явуулахад америк, оросын түншлэл чухал хэмээн Москвагийн олон улсын харилцааны сургуулийн профессор А.Д.Богатуров үзэж байгаа. Энэ нь Зүүн Азид хэтэрхий нөлөөтэй болж буй хятадын нөлөөг зохих хэмжээнд байлгах хүчин зүйл болох ба Орос, Хятадын мөнхийн сөргөлдөөнд оросын хувьд дэмжлэг болох төдийгүй Оросын Алс Дорнодын аюулгүй байдалд гол аюул учруулж болох хятадыг хазаарлах хэтийн зорилготой хэмээн дүгнэж⁷ байгаа.

Оросын судлаач П.Салины “Россия в глобальном мире” сэтгүүлд бичсэн “Россия и Азия или Россия в Азии? Перспективы российской политики в АТР” өгүүлэлд дараахи санааг түлхүү тавьсан байна. Үүнд:

- Геоэдийн засаг гэсэн ойлголт үндэсний аюулгүй байдал гэсэн ойлголтыг давж гарлаа.

- Зүүн Ази нь Европ, Хойд Америкийн бүстэй дүйхүйц дэлхийн бодлогын төв болон хувирч, хөгжлийн хурдсаар тэргүүлэх бүс боллоо.

- Бүс нутгийн хувьд амьдралын төвшин дээшилснээр, дотоод зах зээл рүүгээ хандах болсон /тухайлбал, БНХАУ/

- Энэ бүсийн өрсөлдөх чадварыг дараахи 3 хүчин зүйлд тулгуурласан хэмээн судлаач үзэж байна. А. хямд ажиллах хүч Б. өндөр хуримтлал В. экспортод чиглэсэн үйлдвэрлэл.

ОХУ-ын хувьд Зүүн Азид голлож түншлэх БНХАУ-ын эдийн засгийн амьдрал нь давшингүй байгаа ч нийгэм, улс төрийн системийн хувьд бодлого, үйл ажиллагаандаа “давхар бодолтой” байх нь зүйтэй. Өнөөгийн Хятадын улс төр, нийгмийн тогтвортой байдал нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах давуу байдлыг өгч буй ч хэр удаан хадгалагдах талаар стратегийн бодлогодоо харгалзаж байх ёстой.

Хятадын эдийн засгийн хөгжлийн хурдац ялимгүй л өсөхөд 2020-2025 он гэхэд дэлхийн ДНБ-ний 30 орчим хувь нь түүнд ногдож, дэлхийн хамгийн том эдийн засагт орохоор байна. Зүүн Азид эдийн засгийн хөгжлөөр Хятад тэргүүлсээр байх хэдий ч дотоод асуудал нь төвөг учруулахаар байна. Үүнд:

- хүн амын хөгшрөлт
- хотжилт
- хот, хөдөөгийн ялгаа
- боловсролын салбарын зардлын өсөлт

- банкны системийн бүтцийн өөрчлөлт
- удирдлага, менежментийн болон санхүүгийн зах зээлийн хоцрогдол

Хятадын хувьд хүрээлэн буй “жигжиг” улсуудыг хямд зэвсэг, техникээр хангах замаар зохих хүрээлэл үүсгэх бодит боломжийг түүний эдийн засгийн чадавхи нээж өгч байгаа. Энэ үйл ажиллагаа нь Зүүн Өмнөд Азийн бүсэд илүү бодитой хэрэгжих боломжтой.

ОХУ-ын хувьд Зүүн Азид чиглэсэн идэвхитэй үйл ажиллагаа чухал, бүс нутгийн хамтын ажиллагааны механизмуудад хүрч ажиллах, түүнчлэн эдийн засгийн хамтын ажиллагаанд төрийн дэмжлэг даруй шаардлагатай хэмээн судлаачид бичиж байна.

Оросын Зүүн Азид чиглэсэн бодлого нь “тунхаглал” шинжтэй эсвэл “хэт амбицитай” явах нь түүнийг бүс нутгийн хамтын ажиллагаанаас улам холдуулах төдийгүй бусдын байр суурийг бэхжүүлэх боломж олгож байна гэсэн үг. Гэхдээ Зүүн Ази руу хэтэрхий гүн орж бас болохгүй гэсэн болгоомжилч байгаа. Бүс нутгийн улсуудын хоорондын харилцааны таагүй байдлыг харгалзан үзээд аль нэг улстай хэт ойр байхыг ч үл ойшоох ёстой. Энд Европын түншүүдийн бодол санааг харгалзах нь Оросын хувьд байх л асуудал.

Зүүн Азийн улс орнууд ч гэсэн оросуудыг тийм ч таатай бусаар хандаж европын улс хэмээн үздэг. Бүс нутагт түүний оролцоог эрчим хүчний эх сурвалж нийлүүлэгч, цэрэг-улс төрийн салбарыг, тухайлбал, Япон-Хятад, Хятад-АНУ, АНУ-Япон, Зүүн Өмнөд Ази-АНУ зэргийг тэнцвэржүүлэгч хэмжээнд байлгахыг оросын геополитикууд хүсч байгаа. Оросууд Зүүн Азид шинээр гарахдаа евро-атлантын уламжлалт сэтгэлгээнээсээ салж асуудалд хандах, гэхдээ энэ нь түүний соёл, эдийн засаг, ёс суртахууны үндэс болсон Европын чиглэлээс холдох ёстой гэсэн үг бас биш.

Зүүн Азид гарах оросын эрчим хүчний эх сурвалжийг нийлүүлэх тээвэрлэлтийн дэд бүтцийг олон төрлөөр явуулахыг бүс нутгийн улсууд аюулгүй байдал талаасаа зүйтэй хэмээн үзэж байгаа. Зүүн Азид хамтын ажиллагааг өргөжүүлэх ирээдүйтэй салбарын нэг бол цэрэг-техникийн хамтын ажиллагаа хэмээн оросууд үзэж байгаа хэдий ч өрнөдийн орнуудаас Орост нэлээн шахалт ирдэг ч тал бий. Хятад, Энэтхэгийн зүгээс өндөр технологийн зэвсэг техникийн чиглэлд оросуудтай хамтын ажиллагааг чухалчилж байгаа.

ОХУ-ын нөлөөг Зүүн Ази, Номхон далайд сэргээх талаархи судлаачдын⁸ нийтлэгдүү байр суурь гэвэл:

1. ОХУ нь өөрийн газар зүйн байршлаа ашиглан Европ, Америк, Азийг тив дамнасан тээвэр-холбоо, дэд бүтцийг бий болгосон талбар болох ёстой.
2. Гадаад далайн судалгаа, ашиглалтад тэргүүлэн оролцох ёстой
3. Дорно дахинд, тухайлбал Зүүн Азид Алс дорнодоор дамжуулан эрчим хүчний “зай-батерей” болж хувирах ёстой.

- Дэлхийн эрчим хүчний дэд станц буюу атомын болон бусад эх үүсвэрийн янз бүрийн оврын станцыг байгуулах
4. Дорно дахинд хамгийн хямд цахилгааныг ОХУ л бий болгох ёстой. Энэ нь аливаа дэд бүтцийн болон бусад төслийг хэрэгжүүлэх амин судас нь байх ёстой.
 5. Сибирь, Алс Дорнодын хэд хэдэн субъектыг нэгтгэн Холбооны нэг онцгой бүс болгон энэ чиглэлд хөгжүүлэх ёстой. Энэ бүс нь Амурын онцгой бүс хэмээн нэрлэгдэх нь зүйтэй /Амур муж, Сахалин, Хабаровскийн хязгаарыг эдийн засгийн хувьд зангидах нь зүй ёсны хэрэг/ Гадаад далай, Зүүн Азид гарах гол гарц буюу цонх бол “Амурын онцгой бүс” байна.
 6. АСЕАН+3 эсвэл АСЕАН+6 ч юм уу АТЭС гэсэн “формат”-ийг дэмжин оролцох нь зүй ёсны хэрэг бөгөөд эс тэгвээс бүс нутгаас Оросыг шахах сөрөг үйлдэл эргээд идэвхижинэ.
 7. Зүүн Азийн улс орнуудыг олон улсын сансрын хамтын ажиллагаанд татан оруулж энэ чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлснээр БНХАУ-тай идэвхтэй өрсөлдөх ёстой. Алс Дорнодын “Свободный” аэродромыг ашиглан эргэлтэд оруулах, ингэснээр дэлхийн хэмжээний сансрын хөлөг хөөргөлтийн нэгэн тоглогч шинээр бий болно. /жилд 6-10 нислэг үйлдэнэ/
 8. Алс Дорнодын био нөөцийг ашиглан экспортыг нэмэгдүүлэх, бүс нутгийг хөгжүүлэх өндөр боломж байгааг ашиглах
 9. Алс Дорнодод ОХУ-ын тэргүүлэх байр суурийг бий болгоход гадаад далайн судалгааг эрчимжүүлж, далайн хөтөлбөрийг шинжлэх ухааны байр сууринаас хэрэгжүүлэх

Ийнхүү, сансар огторгуй, далай тэнгисийг хослуулсан хөтөлбөр нь Оросыг Зүүн Ази, Номхон далайд тэргүүлэх байр суурь эзлэхэд гол түлхэц болно гэсэн эрчим хүчнээс гадна өөр том боломжийг эрдэмтэд хэлж байгаа.

Судлаач С.Шипиловын бичсэнээр, Зүүн Ази, Номхон далайд явуулах Оросын бодлого нь “прагматик, уян хатан, ялгавартай шинжтэй байх ёстой” ба бүс нутгаас гарсан интеграцийн агуулга бүхий үйл явцад идэвхитэй байр сууринаас хандах нь зүй ёсны хэрэг.

Гэхдээ, өнөөгийн нөхцөлд “дэлхийн бодлого үзэл сурталжсан байдлаас эрчим хүчний эх сурвалж голлосон байдалд шилжлээ”.⁹ Өөрөө хэлбэл, дэлхийн бодлогод эрчим хүчний хүчин зүйл цэрэг улс төрөөс давамгайлах болж аливаа улсын гадаад улс төрийн бодлого, төрийн стратеги нь эрчим хүчин дээр тулгуурлах болсон. Тухайн улсын эдийн засгийн болоод, аюулгүй байдал нь эрчим хүчний хангамжаас шууд хамааралтай ч боллоо. Иймээс, дэлхий дахинд эрчим хүчний аюулгүй байдалд онцгой анхаарч байна.

- нефтийн зах зээлийн нийлүүлэлтийн хомсдол
- үний өсөлт

- зарим нефть-экспортлогч улсуудын улс төрийн тогтворгүй байдал
- геополитикийн өрсөлдөөн
- эрчим хүчний салбарт үүсч болох бодит сөргөлдөөн
- нүүрс устөрөгчийн бүтээгдэхүүний хэрэглээний тууштай өсөлт

ОХУ-ын гадаад бодлогод эрчим хүчний хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд түүнийг томоохон тоглогч хэмээн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч байгаа. Зүүн Азийн чиглэлд дамжуулах хоолойн хүчин чадлыг үе шаттайгаар өргөжүүлснээр ОХУ нь 2020 он гэхэд Зүүн Азийн орнуудын газрын тосны нийт тэнцэлд 7 хувийг эзэлж, Хятад, Япон, Өмнөд Солонгосын 10 хувийг эзлэх¹⁰ болно. Зүүн Азид Япон, Өмнөд Солонгос, Хятад, ОХУ-ын эрчим хүчний хамтын нийгэмлэг байгуулах үзэл санаа ч бий боллоо. Цаашдаа, эдгээр улсууд эрчим хүчний салбарт ОХУ-ын Зүүн Ази дахь гол түншлэгч нь байх тул энэ чиглэлд томоохон төслүүдийг /тухайлбал, ВСТО/ эхлүүлээд байна.

Зүүн Азийн эдийн засгийн хөгжлийн үр дүнд чөлөөт худалдааны хэлэлцээрийг бүс нутгийн хэмжээнд байгуулахад хүрэх хэдий ч тэр тун өнгөц агуулгатай байх шинжтэй. Нэн ялангуяа, ХАА-н салбарт тун ярвигтай асуудал байх болно. Бүс нутагт асуудал тодорхойлогчийн байр суурийн төлөөх тэмцэлд АНУ, Хятад хоёр өрсөх ба бусад улсуудын хувьд тэдгээрийн бодлогын объект л байх болно. Тэдний хувьд Оросыг хэр татаж чадахаас л Зүүн Азид тэргүүлэгчийн байр нь тодорхойлогдоно гэсэн оросын судлаачдын байр суурь ч байна. Хятадын хувьд өөрийн нэр төр, байр сууриа бэхжүүлэхэд цэргийн хүч чадлаа нэмэгдүүлэх нь гарцаагүй. Энэ эргээд түүний хөршүүдийн хувьд заналхийлал хэмжээнд үнэлэгдэнэ. Үүнийг хөршүүд нь бас хараад суухгүй. Хятадын гадаад улс төрийн бодлогын тэргүүлэх улсуудын жагсаалтад Орос нь 2-3-т бичигдэнэ. Хятадын олон нийт оросыг сайнаар хүлээн авдаг түүхэн уламжлал ч бий. АНУ-ын талаар хятадын зүгээс шууд дайсагнах бодлого барихгүйг хичээж байгаа ч тэд ирээдүйн /2020-2025 оноос цааш тэдний хоорондын асуудал улам төвөгтэй болно/ дайснауд. Япон-Хятадын зөрчил нэмэгдэхэд ч АНУ-ын хувьд эмзэг асуудал болно. Бүс нутгийн лидерүүд болох Япон, Хятад хоёр худалдааны том түншүүд учир зөрчилтэй асуудлаа аль болох хойш нь тавьсаар л байгаа.

Дэлхийн эдийн засгийн хямралд Ази нь нэлээн тогтвортой байдлаа харуулж чадсан. Эдийн засгийн өсөлт нь технологийн болон эрчим хүчний нөөцийг өөртөө ихээр татах боллоо. Энд “эрчим хүчний аюулгүй байдлын асуудал нь олон талт болон хоёр талын харилцааны чухал сэдэв болж байгаа ба бидний оролцоо ч чухал”¹¹ байх болно хэмээн Оросын Гадаад хэргийн сайд бичсэн. Ийм нөхцөлд дахиад л Оросын Сибирь, Алс Дорнодын хүний нөөц, шинэ технологийн хөгжлийн асуудал тавигдаж байна гэсэн үг.

Худалдаа, эдийн засгийн либералчлал, даяарчлалын талаар бүс нутгийн улс орнууд дэмжиж буй хэдий ч далд утгаараа ихэнх улсууд эдийн засгийн алгуур шинэчлэлийг өнөөгийн нийгэм эдийн засгийн болон улс төрийн тогтвортой байдлаа хадгалангаа үргэлжлүүлэх сонирхолтой байгаа нь илт.

ОХУ-ын Дорно дахины талаархи шинэ бодлого нь өөрийн Сибирь, Алс Дорнодын бүсийн хөгжил, Хойд далайн замыг сэргээх бодлогын хүрээнд хэрэгжих ёстой гэсэн судлаачдын байр суурь. Оросын судлаачдын дунд “Шинэ Дорно дахин” гэсэн нэр томъёо үүссэн. Энэ нь Зүүн Ази, Номхон далай, Өмнөд Ази, Ойрхи дорнод, Төв Азийн геополитик, нөхцөл байдал шинээр буй болж байгаатай шууд холбоотой. “Дорно дахины шинэ бодлого” гэдэг нь энэ бүсэд ОХУ-ын байр суурь, оролцоо идэвхитэй бий болгон бэхжүүлэхэд чиглэгдсэн иж бүрэн зорилгот арга хэмжээ. Дэлхий хөгжлийн хамгийн ирээдүйтэй бүс нутгийн хувьд бодлого тодорхойлогч улсуудын анхаарлын төвд орж ирсэн. 50 шахам улс орнуудыг хамарсан, дэлхийн хөгжлийн төв болж буй энэ бүс нутагт явуулах Оросын бодлого нь өөрийн хилийн цэсийн доторхи бодлогоо тэлж бүс нутгийг бүхэлд хамарсан өргөн хүрээнд болгон хувиргаж тэнд өөрийн оройлыг хангах ёстой ба ингэснээр Сибирь, Алс Дорнод “бусдын өгөөш” болгох аюулаас ч аврагдаж чадна. Түүнээс гадна, дэлхийн бодлого тодорхойлогч субъектэд өөрийгөө хамруулж авах боломж ч нээгдэнэ. Түүхий эдийн төлөөх бусдын тэмцлийг хазаарлаж зохистой хөгжлийн зам руу бусдыг чиглүүлсэн алхам болох юм.

Зүүн Азид Япон-Америкийн, Хятад-Америкийн, Өмнөд Солонгос-Америкийн, Тайвань-Америкийн гэсэн нягт түншлэлүүд энэ бүсэд ОХУ-ын байр суурийг нэмэгдүүлэхэд сайнаар нөлөөлөхгүй байгаа ба бүр ч сулруулах талаар хүчтэй лобби хийгдэнэ. Тиймээс судлаачид Номхон далайд цэргийн хүчийг нэмэгдүүлэхээс нааш энэ саад хэвээр байхыг сануулсаар байна. АСЕАН-ШОС-ийг холбох гэсэн Оросын санаачилгыг Зүүн Ази дэмжихгүй байгаа.

3. ДҮГНЭЛТ

Зүүн Азид явуулах Оросын бодлогыг бидний зүгээс тогтмол судлаж, нэн ялангуяа Орос-Хятадын улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны судалгааг түлхүү хийх ёстой.

Оросуудын хувьд хятадын талаархи судалгаа олон зууны туршид хийсэн арвин туршлагатай төдийгүй өнөөгийн олон ургальч нийгэмд санаа бодлоо нээлттэй илэрхийлэх судлаачид ч цөөнгүй болсон. Дотоод, гадаад зардлын бодит харьцааг нягтлан үзэж гадагшаа хандаж явуулах аливаа үйлдэл ямар өртгөөр, ямар үр дагавар авчирч буйг тодорхойлж байх нь чухал.

Оросын эдийн засгийн стратеги нь Хятад, Солонгос, Япон гэсэн 3 улс руу чиглэгдэх боллоо. Харин Зүүн Өмнөд Ази руу үйл ажиллагааг чиглүүлэх шаардлага одоохондоо алга байгаа хэмээн бичиж¹² байна. О.Арины бичснээр, “оросууд бид хүчтэй гэдэг “их гүрний” статусаа хадгалах гэж, хэрвээ тийм статус байхгүй бол олж авах гэж улайран батлан хамгаалах салбарт илүү үр дүнгүй зардал гаргах нь манай эмзэгхэн эдийн засгийг хоосруулах хор уршигтай зүйл” хэмээн тэмдэглэсэн байдагтай олон хүн санал нийлж байгаа. Гаргаж буй зардал эргээд үр дүнгээ өгдөг тийм үйл ажиллагаанд зориулах ёстой. Энэ дүгнэлт нь Монголд ч хамаатай билээ. Тухайлбал, ОХУ нь 2011 онд төсвийнхөө 7,5 хувийг олон улсын үйл ажиллагаанд, 5.8 хувийг батлан хамгаалах салбарт зарцуулж байна.

Орос-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны хэмжээ нь Орос-Японыхоос хавьгүй давуу байх бөгөөд энэ нь тэдгээрийн хоорондын цэрэг, улс төрийн салбарын хамтын ажиллагаанд түлхэц болно. Японтой эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжиж өгөхгүй байгаа үндсэн хоёр шалтгаан бол, нэгд, эдийн засгийн бүтэц тэс өөр, хоёрт, газар нутгийн маргаантай байгаа явдал.

Оросын судлаачдын нийтлэг байр суурь бол Зүүн Азид АНУ л үндсэндээ бүх талаараа зүтгэх хүч болж байна, Япон, Хятадын хувьд тийм хэмжээний нөлөөгүй хэмээн үзэж байгаа. Учир нь америкийн илүүтэй байдлыг зогсоовол бусад хялбар шийдэгдэнэ гэсэн байр суурьтай¹³ байгаа.

Баруун талд НАТО, зүүн талд БНХАУ гэсэн хоёр аюул ОХУ-ын хувьд “мөнхийн айдас” төрүүлсээр байдаг. Орос дангаараа НАТО-тай сөрөх хүч байхгүй, мөн дангаараа БНХАУ-тай сөрөх чадал байхгүй байдаг. Эрт орой нэгэн цагт Орос, Хятадын хоорондын мөргөлдөөн зайлшгүй байдаг. ОХУ-ын улс төрийн хүчнүүдийн байр суурь нь Зүүн Азид явуулах улс төрийн бодлогод онцгой нөлөөтэй байх ба нэн ялангуяа БНХАУ-ын талаархи байр сууринаас илүүд хамааралтай байна.

“Хятадын заналхийлал” гэсэн ойлголт нь ОХУ-ыг НАТО-д тал алдахгүй байдал руу түлхэж байгаа бол НАТО-гийн тэлэлт нь мөн л ОХУ-ыг Зүүн талдаа “хатуу түшицтэй” байхыг ч сануулж байгаа. Ацан шалаанд орсон ОХУ-ын хувьд энэхүү гацааны улмаас Зүүн Азид явуулах бодлого зогсонги байдалд хүрэх нөхцөл гэлтэй. Нөгөө талаас, Өрнөд ч, Хятад ч ОХУ-ыг татахын төлөө тэмцэлдэж байгаа дүр зураг ч гарч байна.

ОХУ нь Зүүн Азийн зах зээл дэх олон улсын хөдөлмөрийн хуваарьт шударга өрсөлдөөний зарчмаар оролцох нь түүний эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлын баталгаа болж зөвхөн Европ гэсэн ганц гарцаа хоёр болгох стратегийн ач холбогдолтой юм. Гэхдээ ОХУ нь Зүүн Азийн бүсэд орж ирэх утвар нөхцөл болгож энэ чиглэлд хэр “зардал” гаргахаас бас хамааралтай төдийгүй энэхүү зардал нь тус

улсыг бүс нутагт нөлөөтэй, эдийн засгийн хамтын ажиллагааны таатай орчинг бүрдүүлсэн ирээдүйн хөрөнгө оруулалт байх ёстой гэдэг талаас нь харахыг зарим /О.Арин/ судлаачид анхааруулж байна. Тэдний бичиж буйгаар, ОХУ-ын гадаад улс төрийн үйл ажиллагааны зардал хумигдсаар байгаа ба тэр нь цаашдаа Оросын улс төрийн нөлөөг хумих бодит нөхцлийн гол шалтгаан¹⁴ хэмээн тодорхойлсон.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Т.В. Бордачёв. “Россия в глобальной политике”. №2, Март-Апрель, 2006
2. А. П. Олейник - Страны мира в цифрах /2011
3. www.gks.ru, www.rosbalt.ru
4. Сергей Лавров. “Россия в глобальной политике”. №2, Март-Апрель, 2006
5. ОХУ-ын Төрийн Думын олон улсын асуудал эрхэлсэн хорооны дарга Ю.А.Квицинскийн ярилцлага. 2007 он
6. Лузянин С.Г. Россия и Китай: В Евразии. М., 2009, с.212.
7. А.Д.Богатуров - с.294
8. “Российском аналитическом обозрении”, №13, 1999 г.,
9. Ким Жи Ен. Энергетическая политика России во взаимоотношениях со странами Северо-Восточной Азии в современных условиях
10. www.vstoneft.ru
11. Сергей Лавров. “Россия в глобальной политике”. №2, Март-Апрель, 2006
12. Арин О. “Азиатско-тихоокеанский регион: мифы, иллюзии и реальность. Восточная Азия: экономика, политика, безопасность” М., 1997
13. К.А.Пензев - писатель-историк, обозреватель Интернет журнала “Новое Восточное Обозрение”
14. Арин О. “Азиатско-тихоокеанский регион: мифы, иллюзии и реальность. Восточная Азия: экономика, политика, безопасность” М., 1997